



АЙМГИЙН МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг: jekbay01@yahoo.com

Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 89838414
Цахим хаяг: Elbegeeuuree@yahoo.com

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.bayan-ulgii.tvet.gov.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрий аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /БӨА-2018/11/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 09-нөөс 2 дугаар сарын 14-ны хооронд хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 25-нд аймаг дах Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 02-ноос 2 дугаар сарын 09-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 14-нд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Боловсролын тухай хууль, **Мэргэжлийн боловсролын тухай** хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв *"Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангах замаар улс, аймгийнхаа эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зөв хандлагатай, өндөр чадамжтай, өндөр орлоготой мэргэжилтэй ажилтан бэлтгэх"* гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэсэн байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д "төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна" гэж заасны дагуу Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны төсвийг Хөдөлмөр, Нийгмийн хамгаалалын яамны сайдын төсвийн багцаас аймгийн төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 19 эрсдэлтэй асуудалд 19 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж мөрдөн ажиллаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн

байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцолох төв ХХК-ны “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын сайдын төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн төсвийн захирагч нь 2017 онд 1386,0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр, 101 орон тоогоор үйл ажиллагаа явуулсан байна. Санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 1367,3 сая төгрөгийг улсын төсвөөс, 18,7 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр тусгагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1360,5 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 10,3 сая төгрөгийн орлого оруулан бүгд 1370,8 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулжээ. Оны эцэст 6,8 сая төгрөгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 18,7 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгдсөнөөс 10,3 сая төгрөг оруулан төлөвлөгөөг 8,4 сая төгрөгөөр буюу 45,0 хувиар тасалсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзэхэд байршилтай холбоотой тогтмол зардлуудаас бусад зардлууд хэмнэлттэй, бусад зардлуудыг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны орон тоог удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 85, үйлчилэх ажилтан 7, гэрээт 8 бүгд 101 орон тоо баталсанаас гэрээтээр 2 харуул цалингийн сандаа багтаан авч ажиллуулж бүгд 103 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулжээ. Дээрхи 2 орон тоог 2015 оноос хойш тогтмол ажиллуулж ирсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2017 оны 1-9 дүгээр сарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар хуулийн 4-р зүйлийн 4.1.3, 6-р зүйлийн 6.1.3, 6.4.5 дахь заалтуудыг зөрчсөн 1358,1 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөгдөж, биелэлтийг 2017.12.25-ны №281 тоотой ирүүлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин, НДШ, ХХОАТ, түлш халаалт, тээвэр шатахуун, хоол, гэрэл цахилгаан зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3.1/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, мөнгөн хөрөнгийн 100 хувь, нийт зардлын 50,0 хувь нь хамрагдсан болно.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй байна. Материаллаг бус асуудлын бүртгэлийн талаар:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс авсан санхүүжилтийн хэмжээг 6797.3 мянган төгрөгийн төвлөрүүлэг шилжүүлэгийн хэмжээгээр бууруулж тайлагнаагүй

Сангийн Сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах журам"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлсэн нь: *Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвийн санхүүжилтийг төвлөрүүлэг шилжүүлэгийн хэмжээгээр буруулж залруулга хийлээ.*

2. Тайлант онд худалдаж авсан 6539.0 мянган төгрөгийн бараа материалыг Бараа материалын тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авсанаар тайлагнаж Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын нягтлан боллох бүртгэл, санхүүгийн тайлан гаргах аргачлал"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлсэн нь: *Бараа материалын тодруулга тайланг засуулж, алдаа арилгав.*

3. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2017 оны оны 01-р сарын 09-ны өдрийн №182/ШШ2017/00081 тоот захирамжаар МСҮТөвийн дарга И.Жанболатад 4943.5 мянган төгрөгийг цалингийн сангаас нөхөж олгосон байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2-т зааснаар ямар нэг арга хэмжээ авагдаагүй байна.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах дансдын тооцоололыг гүйцэд даган мөшгин шалгах боломжгүй байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө, бараа материалын биет тооллого хийх боломж гараагүй учраас гүйцэтгэлийн шалгалтаар хөрөнгийг биет ажиглалтаар тоолох шаардлагатай.

2. Цалин, хоол, хичээл практикийн зардлын гүйцэтгэлийг цаг хугацааны шахуу байдлаас үүдэн түүврийн аргаар үзсэн тул нэмж үзэх шаардлагатай.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

Огноо:2018.02.14

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

Огноо: 2018.02.14